# Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслийн хэрэгжилтийн тайлангийн хүснэгт

| Төслийн нэр | Хэрэгжих хугацаа | Төслийн зорилго | | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | УХОХ-ийн шалгуур үзүүлэлт 2.2 (2024 он) Зорилтот түвшин | УХОХ-ийн шалгуур үзүүлэлт 2.2 (2024 он) Төлөвлөсөн үйл ажиллагаа | 2024 он Хүрсэн түвшин | 2024 он Гүйцэтгэсэн ажил | Төсөвт өртөг | Эх үүсвэр | 2020 оны эцсийн гүйцэтгэл | УХОХ-ийн санхүүжилтийн хуваарь 2.1 (2024 он) | 2024 оны гүйцэтгэл Дүн | 2024 оны гүйцэтгэл Хувь | Нийт гүйцэтгэл Дүн | Нийт гүйцэтгэл Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Ажлын явц** | | | | | | | | **Санхүүжилтийн гүйцэтгэл /сая төг/** | | | | | | | |
| Цар Тахлын Үед Хариу Арга Хэмжээ Авах Нийгмийн Хамгааллын Төсөл-2 | 2021-2025 он | Зорилтот хүн ам, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхдүүдэд үзүүлэх нийгмийн халамжийн дэмжлэгийг сайжруулах | | Цар тахлын үед зорилтот, эмзэг бүлгийн хүн ам, тэр дундаа эмэгтэйчүүд, хүүхдүүдэд чиглэсэн нийгмийн халамжийн дэмжлэгийг сайжруулахад дэмжлэг үзүүлсэн байна. | 0 | 75% | | 70% | | 222,276.9 | Гадаад зээл | 0 | 4,115.3 | 2,594.2 | 63% | 212,153.0 | 95% |
| | | 1. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн нэмэгдлийг олгох | | Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн хэмжээ 2021 оны 1-6, 12-р сарууд сар тутамд нэг хүүхдэд 100,000 төгрөг хүртэл нэмэгдсэн байна. | 0 | - | - | 100% | 2021 - 2023 онд биелсэн | 201,632.8 | Гадаад зээл | 0 | 0 | 0 | 0% | 201,632.8 | 100% |
| | | 2. Нийгмийн халамжийн хөтөлбөр, тогтолцоог бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх | 2.1 ООТА-ыг ашиглан дахин баталгаажуулах судалгаа хийхэд дэмжлэг үзүүлэх | Хамгийн багадаа 26,900 өрхийн ООТА-аар цуглуулсан тоо мэдээг шинэчилсэн аргачлал ашиглан дахин баталгаажуулж, нас, хүйс, газарзүйн бүсээр ангилсан байна | (2020 оны суурь үзүүлэлт: 0 өрх); | 100% | Судалгааны үеэр цуглуулсан мэдээлэл болон төрийн байгууллагуудаас авсан захиргааны мэдээллийг үндэслэн өрхийн оноог бодох.<br>ООТА-аар цуглуулсан тоо мэдээг шинэчилсэн аргачлал ашиглан дахин баталгаажуулж, нас, хүйс, газар зүйн бүсээр ангилах.<br>Үр дүнг нэгтгэн тайлагнах. | 100% | Судалгааны мэдээллээр шинэчилсэн мэдээллийн санг үүсгэж, судалгаанд хамрагдсан 25,768 өрхийн 133,451 иргэний захиргааны мэдээллийг төрийн байгууллагаас цахим хэлбэрээр татан авч, өрхийн оноог 2024 оны 03 дугаар сард бодож, оноо аргачлалын дагуу үнэн зөв бодогдсон эсэхийг шалгах ажлыг ХНХЯ-ны БТГазар болон ХХҮЕГ-аас өгсөн чиглэлийн дагуу гүйцэтгэсэн.<br>2024 оны 6 дугаар сарын 6-ны өдөр C002 дугаартай зөвлөх судалгааны мэдээллийг нас, хүйс, газар зүын бүсээр ангилан дүгнэсэн судалгааны эцсийн тайланг зохих журмын дагуу ГБХНХЯ-нд хүлээлгэн өгсөн. | 1,153.3 | Гадаад зээл | 0 | 160.7 | 60.7 | 0% | 1,052.9 | 91% |
| | | | 2.2 Нийгмийн халамжийн мэдээллийн системийн цахимжуулалтыг дэмжих | Нийгмийн халамжийн 14 хөтөлбөрийг "e-halamj" системд нэмж холбосон байна | (2020 оны суурь үзүүлэлт: 5 үйлчилгээ) | 100% | Нийгмийн халамжийн тайлангийн систем болон халамжийн үйлчилгээний мэдээллийн веб программмын бүрэн нэвтрүүлэлт, тайлангийн систем дээр шинээр орсон маягтууд, цаасан хэлбэрээр шаардагдаж буй баримт бичгүүдийн цахимжилт | 100% | Төслийн хүрээнд 3 бие даасан зөвлөхөөс бүрдсэн баг ХХҮЕГ-ын МТТ-ийн удирдлага доор ehalamj системийн хүрээнд техникийн дэмжлэг үзүүлэн ажилласан.<br>НХМ-1 болон НХМ-1А тайлангийн маягтуудыг хөгжүүлж дуусган уг маягтууд дээр мөн тайлангийн баланс барих боломжгүй байсан тул ХХҮЕГ болон Үндэсний статистикийн хорооноос санал авч НХМ-1, НХМ-1А бүрэн хөгжүүлж дуусгасан. Мөн ХНХЯ-ны BI систем рүү сар бүр халамжийн олголтын мэдээлэл автоматаар илгээх API сервисийн системийг хөгжүүлж, сервер, орчин бүрдүүлж бүрэн ажиллагаанд оруулсан.<br>21 аймаг 9 дүүрэг, ХХҮЕГ-ын НХБХГ-тай хамтран өнгөрсөн хугацаанд хөгжүүлсэн тайлангийн маягтуудыг нягтлан шалгаж гарсан алдаа засваруудыг хийв. Нийт 36 маягтыг хөгжүүлж системд бүрэн нэвтрүүлсэн.<br>Мөн ХХҮЕГ-ын Мэдээллийн технологийн төвөөс өгсөн үүргийн дагуу тухай бүрд програм хангамжийн хөгжүүлэлтийн ажлуудыг гүйцэтгэж ХХҮЕГ-ын өдөр тутмын техникийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн.<br>Халамжийн нийт 64 үйлчилгээ ehalamj системд холбогдсон. | 7,995.0 | Гадаад зээл | 0 | 1,221.3 | 173.4 | 14% | 3,650.9 | 46% |
| | | | 2.3 Төгсөлтийн аргачлалаар туршилтын хөтөлбөр хэрэгжүүлэх | Зорилтот өрхүүдийн хөдөлмөрийн насны 1,500-аас доошгүй тооны насанд хүрэгч (үүнд эмэгтэйчүүд 50%) орлогын эх үүсвэрийг нь дэмжих "төгсөлтийн аргачлал"-аар хэрэгжүүлэх туршилтын хөтөлбөрт хамрагдаж, хөрөнгийн багцыг хүлээн авч, сургалтад хамрагдсан байна | (2020 оны суурь үзүүлэлт: 0 өрх) | 100% | Нэмэлтээр шаардлагатай байгаа амьжиргаа дэмжих тоног төхөөрөмжийн нийлүүлэгчийг эцэслэн тодорхойлж, худалдан авах.<br>Техникийн ур чадвар олгох сургалт явуулах (эд хөрөнгө авахын өмнө ба дараа).<br>Худалдан авалт: өрхүүдэд эд хөрөнгийн худалдан авалт хийхэд дэмжлэг үзүүлэх.<br>Өрхийн тогтмол хяналт үнэлгээг хийх. | 70% | Нэмэлт хөрөнгө шаардлагатай 83 өрхөд, 92 ширхэг тоног төхөөрөмжийг нийлүүлэх ажлыг 03-05 дугаар сард зохион байгуулсан.<br>Хөтөлбөрийн хүрээнд техникийн ур чадвар олгох сургалтад 2024 онд хоол үйлдвэрлэлийн чиглэлээр 218 өрх, гар урлалын (арьсан эдлэл, гутал үйлдвэрлэл) чиглэлээр 69 өрх, нийт 287 өрх хамрагдсан.<br>Оёдлын биезнэс сонгосон 324 өрхөд эргэлтийн хөрөнгийг 2024 оны 02 дугаар сард олгож дууссан.<br>Хөтөлбөрийн өрхийн хяналтыг сар бүр коуч нар цахим системээр дамжуулан мэдээлдэг ба улирал тутам өрхийн ахицын үнэлгээ болон өрхийн хөрөнгө ашиглалтын судалгааг тогтмол зохион байгуулж байна. | 6,422.7 | Гадаад зээл | 0 | 2,177.2 | 1,943.6 | 89% | 4,804.5 | 75% |
| | | 3. Нийгмийн халамжийн шинэчлэлийн чиглэлээрх туршлага судлах, чадавх бэхжүүлэх | | Төгсөлтийн аргачлалын хөтөлбөрийг сайн хэрэгжүүлж буй 2-3 орнуудын туршлагаас судалж, хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд 2-3 гадаад орны туршлагаас судалсан байна.<br>Ядуурлыг бууруулах арга замыг тодорхойлох, төгсөлтийн аргачлалыг нутагшуулах санал, зөвлөмж бэлтгэсэн байна | (2020 оны суурь үзүүлэлт: 0 арга хэмжээ) | 100% | Төгсөлтийн аргачлалын хөтөлбөрийн сайн хэрэгжүүлж буй Филиппин, Индонези улсуудын туршлагаас судлах.<br>Нийгмийн халамжийн эрх зүйн шинэчлэл, ядуурлыг бууруулах хүрээнд гадаад орны туршлагаас судлах. | 70% | ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны А/20 дугаар тушаалын дагуу НХБХЗГ-ын дарга Б.Ундралаар ахлуулсан 9 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Филиппин Улсын нийгмийн халамжийн тогтолцоо, түүний дотор "Төгсөлтийн аргачлал" туршилтын хөтөлбөрийн хэрэгжилтийг судлах, Монгол Улсын ХЭБ-ийн үйлчилгээг хэрэгжүүлсэн туршлагыг танилцуулахаар Филиппин Улсад 2024 оны 02 дугаар сарын 12–ноос 18-ны өдрүүдэд ажилласан.<br>Бүгд Найрамдах Австри Улс (БНАУ)-ын нийгмийн халамжийн тогтолцоотой танилцах, хамтын ажиллагааг хөгжүүлэх болон "Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Австри Улс хоорондын хэлэлцээр"-ийн төслийг хэлэлцэх 2 дахь шатны хэлэлцээг зохион байгуулах зорилгоор ХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2024.05.07-ны А/100 тушаалаар БТГ-ын дарга А.Хишигбаяр, тус газрын ахлах шинжээч Б.Мөнхбаяр, ТЗУГ-ын ахлах мэргэжилтэн Б.Нямсүвд, төслийн Зохицуулагч Ц.Болормаа нар 2024.05.26-наас 31-ний хооронд БНАУ-д ажилласан. Томилолтын удирдамжийн дагуу төлөөлөгчид дээрх хугацаанд Австрийн нийгмийн халамжийн, тэр дундаа хүүхдийн ядуурлын бодлогоос туршлага судалж болон нийгмийн хамгааллын хэлэлцээ хийв. | 280.0 | Гадаад зээл | 0 | 190.0 | 104.9 | 100% | 127.1 | 45% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **ТЕЗ** | | Хэрэгжилтийн хувь*<br>(6.2.1<br>6.2.2) | Үнэлгээ*<br>(6.2.3) | **Нэмэлт тайлбар:**<br>/ажлын явц болон санхүүжилтийн гүйцэтгэл хооронд үүссэн зөрүү зэрэг/ | ТУХ-ны шийдвэрийн дагуу зээлийн дахин хуваарилалт хийх болон төсөл сунгах хүсэлтийг СЯ-аар дамжуулан АХБ-наас зөвшөөрөгдөн, төслийн хамрах хүрээнд өөрчлөлт орсоны дагуу шинэ арга хэмжээнүүд нэмэгдсэн. Ажлын явц болон санхүүжилтийн гүйцэтгэл хооронд бага зэрэг зөрүү байгаа нь шинэ арга хэмжээнүүд нэмэгдсэнтэй холбоотой.<br>2.2.1 C001 дугаартай ООТА-ын олон улсын зөвлөх ажиллуулахгүй болсон тул төсөвт өртөг 328,9 сая төг буурсан. |
| | | 85% | Тодорхой үр дүнд хүрсэн | **Төслийн зорилгын биелэлтэд учирч буй саад бэрхшээл, эрсдэл:** | |
| **ЭЗХЯ** | | Хэрэгжилтийн хувь | Үнэлгээ | Тайлбар: | |

*Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, 2021 оны 374 дүгээр тогтоол "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын холбогдох заалтын арга зүйг ашиглана.